**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2026/277/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр

Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: С.Гантөгс

Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Бадамхатан

Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 249

танай ______________ -ны № ______________ -т

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацаанд тус байгууллагад Нийслэлийн Засаг даргаас захирамжаар 2024 онд худалдан авах ажиллагааны эрх шилжсэн 1, 2025 онд эрх шилжсэн 58 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт болон 15,448,689.9 сая төгрөгийн 401 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажилласан байна. Тухайлбал,

- Он дамжих 139 төсөл, арга хэмжээ;
- Шинээр хэрэгжих 262 төсөл, арга хэмжээ;

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

1423350036
C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\wordтүшээн bichig\2026.02.25 Dugnelt - -.docx

**Аудитын гол асуудал**

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тайлант оны төсөв өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс 41.9 хувиар нэмэгдсэн нь Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоож, нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Нийт төсвийн 83.8 хувийг цалин хөлс, цалингаас тооцсон нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой зардал эзэлж байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд худалдан авах ажиллагаа ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэх бодлогын хүрээнд 4 зорилт дэвшүүлэн, 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл нь 98.5 хувьтай хэрэгжүүлэн ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt - -.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **70,410,780.00** | **58,770,810.16** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **4** | - | - |
| **33** | **АВЛАГА** | **5** | 489,649.00 | 882,831.46 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 489,649.00 | 882,831.46 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | | 3,000,000.00 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | | 3,000,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | 66,921,131.00 | 57,887,978.70 |
| **354** | **Хангамжийн материал** | | 66,921,131.00 | 57,887,978.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 12,451,413.00 | 5,942,126.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 14,701,349.00 | 9,926,145.70 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 39,768,369.00 | 42,019,707.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **334,827,148.73** | **405,178,304.63** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | 334,827,148.73 | 405,178,304.63 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 312,799,537.59 | 379,348,049.09 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 336,768,690.00 | 357,107,630.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (40,434,448.01) | (77,439,242.11) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 39,509,091.50 | 120,060,211.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (23,043,795.90) | (20,380,550.30) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 22,027,611.14 | 25,830,255.54 |
| 39301 | Програм хангамж | | 32,749,000.00 | 40,949,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (10,721,388.86) | (15,118,744.46) |
| **394** | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | **8** | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **405,237,928.73** | **463,949,114.79** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **9** | - | - |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **10** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **405,237,928.73** | **463,949,114.79** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 405,237,928.73 | 463,949,114.79 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 405,237,928.73 | 463,949,114.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 405,237,928.73 | 405,237,928.73 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | - | 58,711,186.06 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **405,237,928.73** | **463,949,114.79** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2** | **1,756,785,122.68** | **2,623,469,166.98** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **290,617,140.00** | **216,896,950.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 290,617,140.00 | 216,896,950.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 290,617,140.00 | 216,896,950.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 36,820,000.00 | 57,120,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 250,000.00 | 250,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 253,547,140.00 | 159,526,950.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **1,466,167,982.68** | **2,406,572,216.98** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 20,186,642.00 | 471,400,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | - | 471,400,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 20,186,642.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | 1,445,981,340.68 | 1,935,172,216.98 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 1,445,981,340.68 | 1,935,172,216.98 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3** | **1,553,712,080.05** | **2,504,602,407.22** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,553,712,080.05** | **2,504,602,407.22** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 1,521,325,232.78 | 1,843,798,759.22 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 1,175,929,528.25 | 1,320,866,145.21 |
| 210101 | Үндсэн цалин | | 595,209,948.01 | 686,926,849.44 |
| 210102 | Нэмэгдэл | | 253,963,209.52 | 253,349,071.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 221,556,735.50 | 261,310,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 105,199,635.22 | 119,280,224.71 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 146,638,113.85 | 161,278,551.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 100,743,449.14 | 110,357,247.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 12,014,461.55 | 13,721,697.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 8,666,406.20 | 7,083,419.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 2,611,654.12 | 6,021,752.48 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 22,602,142.84 | 24,094,434.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 3,978,240.00 | 3,978,240.00 |
| 210304 | Байрны түрээс | | 3,978,240.00 | 3,978,240.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 50,981,062.61 | 58,841,196.13 |
| 210401 | Бичиг хэрэг | | 7,639,156.00 | 24,492,927.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 12,811,400.00 | 11,043,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 9,835,430.61 | 9,669,225.28 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 1,508,981.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | 15,969,795.00 | 10,966,053.35 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 3,216,300.00 | 2,669,190.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 10,580,700.00 | 146,525,100.00 |
| 210604 | Урсгал засвар | | 10,580,700.00 | 146,525,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 1,638,980.00 | 1,700,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,638,980.00 | 1,700,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 42,613,153.70 | 68,632,776.31 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 39,902,153.70 | 63,385,426.31 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 2,711,000.00 | 5,247,350.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 88,965,454.37 | 81,976,750.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 803,800.00 | 2,785,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 850,000.00 | 20,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 87,311,654.37 | 59,191,750.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 32,386,847.27 | 660,803,648.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 17,770,000.00 | 625,933,648.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | - | 112,953,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | - | 53,072,088.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 17,770,000.00 | 459,908,560.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | | 14,616,847.27 | 34,870,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 14,616,847.27 | 34,870,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **203,073,042.63** | **118,866,759.76** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | 178,436,156.96 | 60,155,573.70 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 48,138,294.88 | 60,155,573.70 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | | 130,297,862.08 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | (178,436,156.96) | (60,155,573.70) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **24,636,885.67** | **58,711,186.06** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,503,237,982.68** | **2,463,942,216.98** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **37,070,000.00** | **57,370,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 37,070,000.00 | 57,370,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 37,070,000.00 | 57,370,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 36,820,000.00 | 57,120,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 250,000.00 | 250,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,466,167,982.68** | **2,406,572,216.98** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 20,186,642.00 | 471,400,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 471,400,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,186,642.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,445,981,340.68 | 1,935,172,216.98 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,445,981,340.68 | 1,935,172,216.98 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,487,961,982.68** | **2,436,770,686.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,487,961,982.68** | **2,436,770,686.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,455,575,135.41** | **1,775,967,038.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,175,929,528.25 | 1,321,259,327.67 |
| 210101 | Үндсэн цалин | 595,209,948.01 | 687,320,031.90 |
| 210102 | Нэмэгдэл | 253,963,209.52 | 253,349,071.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 221,556,735.50 | 261,310,000.00 |
| 210104 | Урамшуулал | 105,199,635.22 | 119,280,224.71 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 146,638,113.85 | 161,278,551.17 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 100,743,449.14 | 110,357,247.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,014,461.55 | 13,721,697.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,666,406.20 | 7,083,419.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,611,654.12 | 6,021,752.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,602,142.84 | 24,094,434.46 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 3,978,240.00 | 3,978,240.00 |
| 210304 | Байрны түрээс | 3,978,240.00 | 3,978,240.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 47,620,317.61 | 45,934,215.78 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,084,742.00 | 14,660,872.50 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,811,400.00 | 11,043,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,835,430.61 | 9,669,225.28 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,888,745.00 | 10,560,318.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,124,800.00 | 146,525,100.00 |
| 210602 | Тавилга | 3,000,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 22,124,800.00 | 146,525,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,638,980.00 | 1,700,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,638,980.00 | 1,700,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 48,549,369.70 | 72,506,604.36 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 45,838,369.70 | 67,259,254.36 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,711,000.00 | 5,247,350.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,095,786.00 | 22,785,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,245,786.00 | 2,785,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 850,000.00 | 20,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **32,386,847.27** | **660,803,648.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,770,000.00 | 625,933,648.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 112,953,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 53,072,088.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,770,000.00 | 459,908,560.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 14,616,847.27 | 34,870,000.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,616,847.27 | 34,870,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **15,276,000.00** | **27,171,530.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **15,276,000.00** | **27,171,530.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **15,276,000.00** | **27,171,530.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 15,276,000.00 | 27,171,530.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 15,276,000.00 | 27,171,530.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(15,276,000.00)** | **(27,171,530.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл-** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл-** | | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | - | - | 395,689,383.06 | 395,689,383.06 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (15,088,340.00) | (15,088,340.00) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **380,601,043.06** | 380,601,043.06 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 24,636,885.67 | 24,636,885.67 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **405,237,928.73** | 405,237,928.73 |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **405,237,928.73** | 405,237,928.73 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **405,237,928.73** | 405,237,928.73 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 58,711,186.06 | 58,711,186.06 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **463,949,114.79** | 463,949,114.79 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,173,687,500.0 | 1,957,672,217.0 | (216,015,283.0) | 90.1% |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,173,687,500.0 | 1,957,672,217.0 | (216,015,283.0) | 90.1% |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,956,187,100.0 | 1,781,738,569.0 | (174,448,531.0) | 91.1% |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,465,613,700.0 | 1,321,259,327.7 | (144,354,372.3) | 90.2% |
| Үндсэн цалин | 720,448,100.0 | 687,320,031.9 | (33,128,068.1) | 95.4% |
| Нэмэгдэл | 286,290,900.0 | 253,349,071.1 | (32,941,828.9) | 88.5% |
| Унаа хоолны хөнгөлөлт | 338,800,000.0 | 261,310,000.0 | (77,490,000.0) | 77.1% |
| Урамшуулал | 120,074,700.0 | 119,280,224.7 | (794,475.3) | 99.3% |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 183,201,800.0 | 161,278,551.2 | (21,923,248.8) | 88.0% |
| Тэтгэврийн даатгал | 124,577,200.0 | 110,357,247.7 | (14,219,952.3) | 88.6% |
| Тэтгэмжийн даатгал | 14,656,100.0 | 13,721,697.5 | (934,402.5) | 93.6% |
| ҮОМШӨ-ний даатгал | 7,328,100.0 | 7,083,419.0 | (244,681.0) | 96.7% |
| Ажилгүйдлийн даатгал | 7,328,100.0 | 6,021,752.5 | (1,306,347.5) | 82.2% |
| Эрүүл мэндийн даатгал | 29,312,300.0 | 24,094,434.5 | (5,217,865.5) | 82.2% |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,181,600.0 | 3,978,240.0 | (1,203,360.0) | 76.8% |
| Байрны түрээс | 5,181,600.0 | 3,978,240.0 | (1,203,360.0) | 76.8% |
| **Хангамж, бараа материалын зардал** | 51,500,900.0 | 48,033,915.8 | (3,466,984.2) | 93.3% |
| Бичиг хэрэг | 13,093,700.0 | 14,660,872.5 | 1,567,172.5 | 112.0% |
| Тээвэр, шатахуун | 11,563,200.0 | 11,043,800.0 | (519,400.0) | 95.5% |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,144,000.0 | 9,669,225.3 | (5,474,774.7) | 63.8% |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,700,000.0 | 12,660,018.0 | 960,018.0 | 108.2% |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 154,625,100.0 | 154,596,930.0 | (28,170.0) | 100.0% |
| Тавилга | 8,100,000.0 | 8,071,830.0 | (28,170.0) | 99.7% |
| Урсгал засвар | 146,525,100.0 | 146,525,100.0 | - | 100.0% |
| **Томилолт, зочны зардал** | 1,704,000.0 | 1,700,000.0 | (4,000.0) | 99.8% |
| Дотоод албан томилолт | 1,704,000.0 | 1,700,000.0 | (4,000.0) | 99.8% |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 89,960,000.0 | 89,506,604.4 | (453,395.6) | 99.5% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 67,260,000.0 | 67,259,254.4 | (745.6) | 100.0% |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 22,700,000.0 | 22,247,350.0 | (452,650.0) | 98.0% |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,400,000.0 | 1,385,000.0 | (3,015,000.0) | 31.5% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3,600,000.0 | 1,385,000.0 | (2,215,000.0) | 38.5% |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 800,000.0 | - | (800,000.0) | - |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 217,500,400.0 | 175,933,648.0 | (41,566,752.0) | 80.9% |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 217,500,400.0 | 175,933,648.0 | (41,566,752.0) | 80.9% |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 150,000,000.0 | 112,953,000.0 | (37,047,000.0) | 75.3% |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 55,500,400.0 | 53,072,088.0 | (2,428,312.0) | 95.6% |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 12,000,000.0 | 9,908,560.0 | (2,091,440.0) | 82.6% |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,173,687,500.0 | 1,957,672,217.0 | (216,015,283.0) | 90.1% |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,151,187,500.0 | 1,900,302,217.0 | (250,885,283.0) | 88.3% |
| Орон нутгийн төсвөөс | 2,151,187,500.0 | 1,900,302,217.0 | (250,885,283.0) | 88.3% |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 22,500,000.0 | 57,370,000.0 | 34,870,000.0 | 255.0% |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 22,500,000.0 | 57,120,000.0 | 34,620,000.0 | 253.9% |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 250,000.0 | 250,000.0 | |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 40 | 36 | (4) | 90.0% |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0% |
| Гүйцэтгэх ажилтан | 39 | 35 | (4) | 89.7% |
| Үйлчлэх ажилтан | - | - | - | - |
| Гэрээт ажилтан | - | - | - | - |
| **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **40** | **36** | (4) | 90.0% |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 35 | 31 | (4) | 88.6% |
| Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 3 | 3 | - | 100.0% |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 2 | 2 | - | 100.0% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **471,400,000.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **471,400,000.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 21,400,000.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,400,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1,400,000.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,000,000.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 450,000,000.00 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 450,000,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 450,000,000.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 471,400,000.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 471,400,000.00 |

| | |
|---|---|
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 471,400,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 110,704.8 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулсан.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Батлагдсан төсөв, гүйцэтгэл нь төсвийн хэлбэлзлийн тайлангаас зөрүүтэй. | 1 | 15,205.5 | | | 1 | 15,205.5 | 1 | 15,205.5 | | | | |
| Хагас жил болон жилийн эцсийн тооллогоор тооллогын комиссын тоолсон хөрөнгийн тоо ширхэг нь эд хариуцагчийн картаар бүртгэлтэй хөрөнгөөс илүү байна. | 1 | 95,499.3 | 1 | 95,499.3 | | | 1 | 95,499.3 | | | | |
| **Дүн** | **2** | **110,704.8** | **1** | **95,499.3** | **1** | **15,205.5** | **2** | **110,704.8** | | | | |

Аудитаар нийт 22,198.6 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өмч хамгаалах байнгын зөвлөлийн /өөрийн үндсэн чиг үүргийн ажлаа хийж | 1 | 10,018.0 | | | | | 1 | 10,018.0 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| буй нягтлан бодогч, нярав орсон/ гишүүдийн ажлын байрны чиг үүргийн давхардал болон ажлын үр дүнг үнэлж дүгнэлгүйгээр жилд 2 удаа урамшуулал олгосон. | | | | | | | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн. | 1 | 5,762.5 | | | | | 1 | 5,762.5 | | | | |
| Бараа материалыг ангиллын дагуу бүртгээгүй,аж ахуйн материалын дансанд хүнс, бэлэн бүтээгдэхүүн, засварын ажлын материалуудыг бүртгэсэн. | 1 | 6,418.1 | | | | | 1 | 6,418.1 | | | | |
| Үлдэх өртөггүй, элэгдэл нь дууссан, цаашид дахин үнэлэх, актлах шаардлагатай 10 нэр төрлийн 44 ширхэг 17.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **4** | **22,198.6** | | | | | **4** | **22,197.6** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 2024 оны 8 сард орсон Нийслэлийн агентлагуудын шинэ байрны 296 м.кв талбай /дарга, бичиг хэрэг, мэдээллийн технологийн хэлтсийн өрөө болон цайны өрөө/-д засвар хийж, төсвөөс 146.5 сая төгрөгийн засварын зардал гаргасан. | 1 | - | | | | | 1 | - |
| Нийт албан хаагчдын 67 хувьд нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор НЗД-ын захирамж, ТШЗ-ийн тушаалаар нийт 543.6 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг мөнгөн дүнг ялгавартайгаар, дийлэнхэд хавтгайруулан олгосон. | 1 | - | | | | | 1 | - |
| **Дүн** | 2 | - | | | | | 2 | - |